



**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,
Цахим шуудан: info@ags.gov.mn,
Цахим хуудас: www.ags.gov.mn

2024.01.25 № 01/53


танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ,
ХӨГЖЛИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Танаас ирүүлсэн 2024 оны 01/139 дүгээр албан бичгийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны “2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай” 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Монгол Улсын Их Хурлын 2001 оны “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” 57 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хүргүүлж байна.

Хавсралт 8. хуудастай.

ДАРГА



Б.БААСАНДОРЖ

9023010230 CTC3950 6975747

15160 0 0068

**“МОНГОЛ УЛСЫН БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ
ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2001 ОНЫ 57 ДУГААР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2024 оны 01 дүгээр
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

“Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг тодорхойлох арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 07 дугаар тогтоол, “2024 оныг бүсчилсэн хөгжлийг дэмжих жил болгон зарлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 481 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарын 2024 оны А/20/08 дугаар хамтарсан тушаалаар ““2024 оныг ”Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарлах тухай” 481 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх 100 хоногийн ажлын төлөвлөгөө”-г баталсан.

Тус төлөвлөгөөний 2.1-д “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийн нэгдсэн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт даалгасны дагуу тус тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг танилцуулж байна.

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг тооцож, дүнг танилцуулахад оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалыг баримтлан Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д ирүүлсэн тайлан, мэдээллийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг тооцохдоо “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”-ын 1.5-д заасны дагуу 3 заалтыг сонгон авч, хэрэгжилтийг үнэлэв. Үүнд:

1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3 дахь заалт буюу дэвшүүлсэн 6 зорилтын хэрэгжилт;

2.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7 дахь заалт буюу 43 бодлогын хэрэгжилт;

3.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.5 дахь заалт буюу бүсүүдийн тэргүүлэх 22 чиглэлийн хэрэгжилт.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3 дахь заалт буюу 6 зорилтын хэрэгжилт

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3-т төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчныг хамгаалах, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны хүрээний 6 зорилтыг дэвшүүлж, тэргүүлэх ач холбогдолтой гэж үзжээ.

Зураг 1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилт



Дээрх 6 зорилтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зорилт тус бүрээр хэрэгжилтийг харуулбал:

График 1.Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт, зорилтоор



Эх сурвалж: new.unelgee.gov.mn

Төрийн байгуулалтын зорилтын хэрэгжилт 54.6 хувь буюу хамгийн өндөр хэрэгжилттэй, гадаад хамтын ажиллагааны зорилтын хэрэгжилт 31.7 хувь буюу хамгийн бага хэрэгжилттэй байна.

Дүгнэвэл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 2.3 дахь заалт буюу төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, байгаль орчныг хамгаалах, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны зорилтын хэрэгжилт дунджаар **45.5 хувь** байна.

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7 дахь заалт буюу бодлогын хэрэгжилт

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7-д дээр дурдсан 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх **43** бодлогыг баталсан ба хэрэгжилтийг бүс болон яамдаар ангилан харуулбал:

Хүснэгт 1.Бодлогын хэрэгжилт, бүсээр

№	Бүсийн нэр	Бодлого (тоо)	Хэрэгжилтийн хувь					Дундаж хувь
			100	70	30	0	ХБ	
1	Баруун бүс	29	5	11	10	1	2	56.5
2	Хангайн бүс	28	1	15	5	4	3	51.3
3	Төвийн бүс	29	4	14	6	3	2	57.3
4	Зүүн бүс	28	1	16	8	3	-	52.9
5	Улаанбаатар бүс	24	8	8	3	-	5	69.4
Нийт								56.7

Эх сурвалж: new.unelgee.gov.mn

Улаанбаатарын бүсэд хамаарах бодлогын хэрэгжилт 69.4 хувь буюу хамгийн өндөр хэрэгжилттэй, Хангайн бүсэд хамаарах бодлогын хэрэгжилт 51.3 хувь буюу хамгийн бага хэрэгжилттэй байна.

Хүснэгт 2.Бодлогын хэрэгжилт, яамдаар

№	Яамны нэр	Бодлого (тоо)	Хэрэгжилтийн хувь				Дундаж хувь
			100	70	30	0	
1	Эдийн засаг, хөгжлийн яам	16	-	7	8	1	45.6
2	Гадаад харилцааны яам	2	-	1	1	-	50.0
3	Сангийн яам	7	-	4	3	-	52.9
4	Хууль зүй, дотоод хэргийн яам	2	-	2	-	-	70.0
5	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	8	-	7	1	-	65.0
6	Барилга, хот байгуулалтын яам	8	-	1	7	-	35.0
7	Боловсрол, шинжлэх ухааны яам	1	-	1	-	-	70.0
8	Зам, тээврийн хөгжлийн яам	4	-	2	2	-	50.0
9	Соёлын яам	1	-	1	-	-	70.0
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	1	-	1	-	-	70.0
11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	5	-	1	1	3	20.0
12	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	4	-	2	2	-	50.0
13	Цахим хөгжил, харилцаа холбооны яам	1	-	-	1	-	30.0
14	Эрчим хүчний яам	1	-	1	-	-	70.0
15	Эрүүл мэндийн яам	1	-	1	-	-	70.0
Нийт							48.4

Эх сурвалж: new.unelgee.gov.mn

Яамдын 46.7 хувь нь бодлогын хэрэгжилтийг 70.0 хувь хангаж ажилласан бол Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны бодлогын хэрэгжилт 20 хувь буюу хамгийн бага хэрэгжилттэй байна.

Дүгнэвэл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7-д тусгасан **43** бодлогын хэрэгжилт **52.5 хувь** байна. Дэлгэрэнгүй тайланг хавсаргав.

**Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.5 дахь заалт
буюу бүсүүдийн тэргүүлэх 24 чиглэлийн хэрэгжилт**

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.5-д бүсүүдийн байгаль, түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг харгалзан тэргүүлэх чиглэлийг бүс бүрээр баталсан ба 2010-2023 оны тэргүүлэх чиглэлийн статистик мэдээлэл, орон нутгийн хөгжлийн индексийг харьцуулж харуулбал:

Баруун бүсийн тэргүүлэх 3 чиглэлийн статистик мэдээлэл

Хүснэгт 3. Баруун бүсийн тэргүүлэх чиглэлийн статистик мэдээлэл

№	Тэргүүлэх чиглэл	2001 он	2005 он	2010 он	2015 он	2020 он	2023 он
1	Бэлчээрийн мал аж ахуй (малын тоо толгой)	7587.3	9241.9	7418.5	13711.2	15845.2	14316.2
2	Усалгаатай тариалан (га)	8939.8	8634	13004.1	15415.5	42059.3	54388.7
3	Жижиг, дунд үйлдвэр (хуулийн этгээдийн тоо)	363	501	615	748	853	997

Эх сурвалж: Баруун бүсийн тайлан

Хангайн бүсийн тэргүүлэх 7 чиглэлийн статистик мэдээлэл

Хүснэгт 4. Хангайн бүсийн тэргүүлэх чиглэлийн статистик мэдээлэл

№	Тэргүүлэх чиглэл	2001 он	2005 он	2010 он	2015 он	2020 он	2023 он
1	Бэлчээрийн мал аж ахуй (малын тоо толгой)	1869.1	2301	2010.5	4511	4479.1	4734.6
2	Амралт, сувилал (тоо)	4	7	9	10	17	20
3	Газар тариалан (га)	43585.0	38560.8	60488.9	77595.9	98454.9	116904.2
4	Аялал жуулчлал	-	-	-	-	-	-
5	Жижиг, дунд үйлдвэр (хуулийн этгээдийн тоо)	97	113	160	330	686	715
6	Уул уурхай (хуулийн этгээдийн тоо)	3	3	3	4	4	6
7	Мод боловсруулах үйлдвэр (тоо)	4	6	16	15	12	13

Эх сурвалж: Хангайн бүсийн тайлан

Төвийн бүсийн тэргүүлэх 8 чиглэлийн статистик мэдээлэл

Хүснэгт 5. Төвийн бүсийн тэргүүлэх чиглэлийн статистик мэдээлэл

№	Тэргүүлэх чиглэл	2001 он	2005 он	2010 он	2015 он	2020 он	2023 он
1	Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй (малын тоо толгой)	359.4	360.4	499.7	576.7	721.2	522.6
2	Газар тариалан (га)	20767.2	18832.9	31212.7	11632.7	41744.5	50682.6

3	Уул уурхай (борлуулалтын орлого, сая.төг)	11037.8	8435.7	21169.2	57396.5	290063.9	120858
4	Боловсруулах үйлдвэр (борлуулалтын орлого, сая.төг)	5050.3	28326.6	64461.2	95456.5	81278.2	412080.3
5	Жижиг, дунд үйлдвэр (хуулийн этгээдийн тоо)	1142	1203	1266	1333.8	1404	1562
6	Аялал жуулчлал (аялагчдын тоо)	5467	10605	12256	36948	19999	153991
7	Амралт сувиллын үйлчилгээ (хуулийн этгээдийн тоо)	1	1	2	3	4	4
8	Оюуны багтаамж ихтэй бусад үйлдвэрлэл, үйлчилгээ	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Төвийн бүсийн тайлан

Зүүн бүсийн тэргүүлэх 6 чиглэлийн статистик мэдээлэл

Хүснэгт 6. Зүүн бүсийн тэргүүлэх чиглэлийн статистик мэдээлэл

№	Тэргүүлэх чиглэл	2001 он	2005 он	2010 он	2015 он	2020 он	2023 он
1	Уул уурхай (хуулийн этгээдийн тоо)	-	-	-	2690	3129	3310
2	Боловсруулах үйлдвэр (тоо)	-	-	-	-	257	261
3	Эрчимжсэн газар тариалан (га)	13475.2	16970.1	15167.1	94639.1	64150.9	81405.4
4	Мал аж ахуй (малын тоо толгой. сая)	3579.9	4191.4	5273.8	8176.9	11311.2	11412.2
5	Жижиг, дунд үйлдвэр (хуулийн этгээдийн тоо)	-	7	36	52	99	180
6	Аялал жуулчлал (аялагчдын тоо)	-	-	10867	48218	94046	16347

Эх сурвалж: Зүүн бүсийн тайлан

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.5-д тусгасан бүсүүдийн тэргүүлэх чиглэлийн хүрэх түвшинг тодорхойлоогүй тул хэмжих боломжгүй байна. Гэвч бүсүүдийн тэргүүлэх чиглэлийн статистик үзүүлэлт 2001-2023 онуудад тогтмол өссөн үзүүлэлттэй байна.

Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлалыг "Хөгжлийн индексийн тухай" Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 88 дугаар тогтоол, "Аргачлал шинэчлэн батлах тухай" 2018 оны 20 дугаар тогтоолоор баталж, тус аргачлалаар тооцож гаргасан орон нутгийн хөгжлийн индексийг жил бүрийн I улиралд багтаан нийтэд зарлаж байхыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан.


Тухайн бүсэд хамаарах аймгийн “Орон нутгийн хөгжлийн индекс”-үүдийн нийлбэрээр бүсүүдийг нэгтгэн харуулбал:

Хүснэгт 7.Орон нутгийн хөгжлийн индекс, бүсээр

Бүсийн нэр	2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Баруун бүс	0.569	0.516	0.519	0.542	0.509	0.504	0.515
Хангайн бүс	0.580	0.532	0.526	0.544	0.525	0.534	0.544
Төвийн бүс	0.618	0.559	0.560	0.582	0.556	0.561	0.556
Зүүн бүс	0.562	0.511	0.498	0.522	0.505	0.507	0.504

Эх сурвалж: <http://med.gov.mn/>

График 2.Орон нутгийн хөгжлийн индекс, бүсээр



Эх сурвалж: <http://med.gov.mn/>

Дээрх графикаас Баруун бүсийн орон нутгийн хөгжлийн индекс 0.081 нэгж хувиар, Хангайн бүсийн орон нутгийн хөгжлийн индекс 0.036 нэгж хувиар, Төвийн бүсийн орон нутгийн хөгжлийн индекс 0.114 нэгж хувиар, Зүүн бүсийн орон нутгийн хөгжлийн индекс 0.058 нэгж хувиар тус тус буурсан байна.

Дүгнэвэл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсийн тэргүүлэх чиглэлийн хүрэх түвшинг тодорхойлж, батлаагүй тул тус үзэл баримтлалын 4.5 дахь заалт буюу бүсүүдийн тэргүүлэх 24 чиглэлийн хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна.

Дөрөв.Дүгнэлт

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг **49.02 хувь** буюу “хэрэгжилт хангалтгүй” гэж үнэлэв.

Үнэлгээний задаргааг хүснэгтээр үзүүлбэл:

			Хүснэгт 2.Хэрэгжилтийн үнэлгээ
№	Хэрэгжилт тооцсон заалтын агуулга	Хувь	Үнэлгээ
1	Зорилтын хэрэгжилт	45.5	“Хэрэгжилт хангалтгүй”
2	Бодлогын хэрэгжилт	52.6	“Хэрэгжих шатанд”
		49.02	“Хэрэгжилт хангалтгүй”

Тэргүүлэх чиглэлийн хэрэгжилтийг үнэлгээнээс хасч тооцов.

Анхаарах асуудал:

1.Бүсчилсэн хөгжлийн тухай хууль тогтоомжийг хяналтад аваагүй, хэрэгжилтийг тооцож байгаагүй:

Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn) 2014 оноос хэрэглээнд нэвтэрсэн боловч уг цахим санд хүчин төгөлдөр үйлчилж буй Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2001 оны 57 дугаар тогтоолыг хяналтад аваагүй тул хэрэгжилтийг тооцож байгаагүй байна;

2.Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа дуусгавар болсон:

Монгол Улсын Их Хурал 2003 онд "Бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010 он хүртэл)"-ийг, Монгол Улсын Засгийн газар 2005 оны 202 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Баруун бүсийн хөгжлийн хөтөлбөр, 2 дугаар хавсралтаар Хангайн бүсийн хөгжлийн хөтөлбөр, 3 дугаар хавсралтаар Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр, 4 дүгээр хавсралтаар Зүүн бүсийн хөгжлийн хөтөлбөрийг, 2006 оны 197 дугаар тогтоолоор Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрийг 2006-2015 онд хэрэгжүүлэхээр тус тус баталсан. Эдгээр бүсчилсэн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа 2015 онд дуусгавар болсон, шинэчлэн батлаагүй байна;

3.Хэрэгжилтийг яам, аймаг, бүсийн төвүүд хангалтгүй тайлагнасан:

Бүсчилсэн хөгжлийн талаарх хэрэгжилтийг яам, аймаг, бүсийн төвүүд 2015 оноос хойш тайлагнаагүйтэй холбогдуулан хэрэгжилтийг бүрэн бус, хэт ерөнхий (зарим нэгж зөвхөн 2023 оны хэрэгжилт тайлагнасан) тайлагнасан;

4.Тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх боломжтой байдлаар боловсруулах:

Бүсчилсэн хөгжлийн хөтөлбөрийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн зорилго, зорилт, санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан үйл ажиллагаа бүхий, тоон болон чанарын шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх боломжтой байхад анхаарах.

Хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайланг QR кодоор хавсаргав.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР